



САЙХАН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.МЯДАГМАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.14 № 01/05 ДУА-2017/106/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо 480,000.00 /Дөрвөн зуун наян мянга/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцолгүй илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1-т /Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна/, 32.1.4-т /аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-т /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 480,000.00 /Дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутган тооцож, Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100081220001 тоот дансанд 2017 оны 04 дугаар сарын 05-ны дотор төвлөрүүлэх;

Актын биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Мядагмаа, нягтлан бодогч З.Цэдэнрулам нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР



ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА




С.МЯДАГМАА

НЯГТЛАНБОДОГЧ



З.ЦЭДЭНРУЛАМ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.